

## Жишээ, 2-р хэсэг

Мөнхийн гэрлэлтийн институтын хичээлийн дараа Луис, Эмма хоёр хоёулаа зарим өөрчлөлтийг хийж мөн Их Эзэнд илүү итгэх болсон. Луис дараагийн долоо хоногийн институтын хичээлд ирэхдээ Эммагийн хажууд сууж, өөрийгөө танилцуулав. Хэсэг хугацаа өнгөрөхөд тэд сайн найзууд болжээ. Тэд хамтдаа цагийг өнгөрөөж, бие биеийнхээ талаар сурч мэдэх олон үйл ажиллагааг төлөвлөдөг байв. Цагийн аясаар тэд бие биедээ дасаж эхлэв.

Гэхдээ Эмма зарим нэг зүйлд санаа зовниж байлаа. Түүнд өөрийн нөхөрт байлгахыг хүсдэг зан чанарын жагсаалт байдаг байв. Луист эдгээр зан чанарын олонх нь байсан боловч бүгд байхгүй байлаа.

Луис түгшиж эхэлжээ. Тэр Эммад хайртай боловч эцэг эхийнхээ гэрлэлтийг бүтэлгүйтсэнийг харснаасаа болж гэрлэх хүнээ сонгохдоо алдаа гаргахаас айдаг байлаа. Тэр Эмматай ярилцсан яриа, хуримтлуулсан туршлага зэргээс түүний талаар сурсан бүх зүйлээ сайтар бодож үзжээ. Түүнд тэдний зорилго нийлж байгаа мэт санагдаж, Эммагаас гэрлэхийг гуйхыг хүсдэг боловч олон мэдэхгүй хүчин зүйл байсаар байлаа. Луис Эммаг сонгох нь зөв гэдэг тэмдэг хүсэн залбирив. Гэхдээ ямар ч хариу одоогоор ирээгүй байлаа.

- Бэлтгэх материалын 2-р хэсгээс сурсан зүйлээ бод. Боломжит ханиа хайх Эммагийн хандлагад юу тусалж болох вэ? Боломжит ханьдаа тавих бидний хүлээлт хэт бага эсвэл хэт өндөр байвал бидэнд ямар асуудал тулгарч болох вэ?
- Луист өөрийн айдсын талаар ойлгоход юу тусалж болох вэ? Илчлэлт хүлээн авах талаар ойлгоход түүнд юу тус болж болох вэ? (Та бэлтгэх материалын 3-р хэсгийг дахин үзэж болно.)
- Хоёр хүн нөхөрлөлийг хөгжүүлж, бие биеийнхээ зан чанар, үнэт зүйлсийн талаар илүү сайн мэдэж авахад ямар үйл ажиллагаанууд туслах вэ? Гэрлэлтэд бэлдэх эсвэл гэрлэх явцдаа үргэлжлүүлэн хөгжүүлэхээр найдаж буй Аврагчийн ямар нэг эсвэл хоёр зан чанар байдаг вэ?